

**ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Э.ЭНХТУЯАГИЙН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	
	1	2	3	4	5	6
Зорилт 1. Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах						
1	Олон улсад гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судалж, боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Бодлогын баримт бичиг болон үндэсний хөтөлбөр, хууль тогтоомжид тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулан, хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн гаргаж, хугацаанд нь тайлагнана.	<p>ДГБ, ДХБ-аас гаргасан бодлогын баримт бичиг, албан бичиг, мэдээ мэдээлэл зэрэг 85 албан захидал 135 мэйл хүлээн авч орчуулан ГЕГ-ын удирдлагуудад танилцуулан холбогдох мэдээллийг албан хаагчдад СЕРР болон СПАРК системээр түгээсэн. (Үүнд: тэтгэлэгт хөтөлбөр, фото зургийн уралдаан, эксперт багшаар ажиллах урилга, нийтлэл илгээх урилга г.мэт)</p> <p>Түүнчлэн олон улсын гаалийн чиглэлийн төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран ажиллаж, 73 уулзалт, форум, сургалт зохион байгуулахад оролцож, нийт 174 албан хаагчийг хамруулсан;</p> <p>“Олон Улсын гаалийн өдөр 2024” өдөрлөгийг зохион байгуулж ГЕГ-ын нийт албан хаагчид болон ГГХ-ыг цахимаар оролцуулан ДГБ-ын баярын бичгийг 20 албан хаагчид гардуулсан. Өдөрлөгийн хүрээнд бэлтгэсэн мэдээллүүдийг СЕРР системийн Гадаад арга хэмжээ талбарт байршуулсан (Хандалт: 511).</p> <p>ДГБ, ДХБ, бусад олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулсан болон оролцсон 22 (гаалийн хяналт, шалгалт, зөрчил, барааны ангилал, гарал үүсэл, эрсдэлийн удирлагыг хэрэгжүүлэх, хамтын ажиллагаа, тариф, татвар гэх мэт чиглэлээр) арга хэмжээний баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн (орчуулсан материал: 83 хуудас).</p>	01.01-11.30
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”						
1	Албан хаагчдыг гадаад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулсан байдал, үр	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Албан хаагчдыг гадаадад болон гадаадын экспертүүдийн сургалтад хамруулах, сургалтын үр дүн гаалийн	<p>ДГБ, ОУВС, НҮБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон, Тайван, Тайланд, Швейцарь болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран цахим болон биет хэлбэрээр нийт 94 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 354 албан хаагч хамруулснаас ГЕГ-аас 261 (73,7%); ГГХ 93 (26,3%) албан хаагчийг хамруулхад оролцож ажилласан.</p> <p>Үүнээс дурдвал:</p>	01.01-11.30

	<p>дүнг тооцох ажлыг зохион байгуулсан байдал</p>			<p>байгууллагын үйл ажиллагаанд хэрэгжиж үр дүнгээ өгөх. Үүнд: Гадаад хамтын ажиллагааны хүрээнд хоёр талт болон олон талт 15 уулзалт; - Олон талт болон хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд 5 сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Япон Улсын Токио хотноо “Бүрдүүлэлтийн дараах шалгалт болон Барааны ангилал, үнэлгээ” чиглэлээрх сургалтанд 14 албан хаагчийг хамруулсан. - ДГБ-ын Гарал үүсэл үндэсний семинар, ОУВС-ийн “Мөнгө угаахтай тэмцэх” үндэсний семинарыг МУ-д зохион байгуулан 68 албан хаагчийн хамруулсан. - ДГБ- Швейцарын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан “Глобал Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр”-ийн хоёрдугаар шатны төсөлд хамрагдахаар болсон. - БНСУ-тай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Монголын гаалийн байгууллагын 10 албан хаагчийг БНСУ-ын Инчеон бүсийн гаалийн байгууллагатай танилцуулах, туршлага судлах сургалтыг 2024 оны 10 сарын 21-25-ны өдрүүдэд БНСУ, Инчеон хотод амжилттай зохион байгуулсан байна. - Түүнчлэн БНСУ-тай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийн 4 албан хаагчийг Монгол Улсын гаалийн байгууллагатай танилцуулах, туршлага судлуулах уулзалт, арга хэмжээг 2024 оны 11 сарын 11-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулсан байна. - ДГБ-ын “ДГБ-ын бүс нутгийн гаалийн лабораторийн мэргэжилтэнийг чадавжуулах хөтөлбөр”-ийг СПАРК системээр зарлаж үүний үр дүнд Гаалийн төв лабораторийн ГУБ О. Доржханд БНСУ, Бельгийн Хаант Улсын Брюссель хотноо мэргэжил , ур чадвараа дээшлүүлэх 45 хоногийн сургалтад хамрагдсан байна. - Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас (ЖАЙКА) 2024 оны 10 дугаар сарын 07-ноос 11 дүгээр сарын 01-ний хооронд зохион байгуулагдсан “Customs Administration” сэдэвт богино хугацааны сургалтын мэдээллийг СПАРК системээр түгээж шаардлага хангасан Ч. Мөнххишиг Гаалийн байгууллагаас хамрагдсан байна. - БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас зарласан 2 жилийн Магистрын хөтөлбөрийн мэдээллийг СПАРК системээр түгээж шаардлага хангасан Т. Тэмүүлэн БНСУ-ын Эвха Эмэгтэйчүүдийн сургуульд Магистрын хөтөлбөрт суралцаж байна. 	
--	---	--	--	---	--	--

					- Япон Улсын Хүний нөөцийн хөгжлийн байгууллагаас (JDS) зарласан 2 жилийн Магистрын хөтөлбөрийн мэдээллийг СПАРК системээр түгээж шаардлага хангасан 2 албан хаагч Япон Улсад суралцаж байна.	
2	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилах, холбоо баригчийн үүрэг гүйцэтгэх ажлыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилж, гаалийн асуудлаар холбоо баригчийн үүрэг гүйцэтгэн ажиллана.	АНУ, Япон, БНСУ, Узбекистан, Казахстан, Тайланд зэрэг улс орнуудтай хамтран ажиллах хүрээнд хамтын ажиллагааны төсөл хөтөлбөр, ААН-үүдийн барааны экспорт болон импортын гаалийн мэдүүлэг, дагалдах бичиг баримтын тодруулга, гаалийн зөрчил болон хяналт шалгалтын чилгэлээр 775+ албан бичиг 1750+ гаруй цахим захидал солилцож хамтран ажиллаж холбоо баригчийн үүрэг гүйцэтгэхэд оролцож ажилласан. ДГБ, ОУВС, НҮБ, АНДЭЗНК, КОЙКА, АХБ, КАРЕК, АНУ, Япон, БНСУ, БНХАУ, ОХУ, Австрали, Тайван болон бусад орны гаалийн байгууллагатай хамтран ажиллаж 775+ гаруй албан бичиг 1750+ цахим захидал солилцож тулгамдсан асуудал, албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр тухайн улсуудад 73 хурал, уулзалт, сургалтад 174 албан хаагчыг хамруулсан. Түүнчлэн холбоо барьж ажилласаны үр дүнд: <ul style="list-style-type: none"> - ДГБ-ын “Гарал үүсэл үндэсний семинар” МУ-д зохион байгуулан 45 албан хаагчийн хамруулсан. - ОУВС-ийн “Мөнгө угаахтай тэмцэх” үндэсний семинарыг МУ-д зохион байгуулан 68 албан хаагчийн хамруулсан. - ДГБ- Швейцарын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан “Глобал Худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр”-ийн хоёрдугаар шатны төсөлд хамрагдахаар болсон. - Австрали улсын Сидней хотноо энэ оны 04 дүгээр сард зохион байгуулагдсан ДГБ-ын АНДБН-ийн гаалийн байгууллагын дарга нарын 25 дугаар хуралд ГЕГ-ын дарга оролцож бусад орны гаалийн байгууллагын дарга нартай биечлэн уулзаж монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилж цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцсон. - ДГБ-ын “ДГБ-ын бүс нутгийн гаалийн лабораторийн мэргэжилтэний хөтөлбөрт” хамрагдахаар болсон. - Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-ын ээлжит 143/144-р чуулга уулзалт 2024 оны 06-р сарын 27- 29-ний өдрүүдэд Бельгийн Хаант Улсын Брюссель хотноо зохион байгуулагдсан бөгөөд энэхүү арга хэмжээний Монгол Улсын Улсын их хурлын ээлжит сонгуультай давхцаж байсан тул биечлэн оролцох боломжгүйгээ мэдэгдэж Монгол Улсын Гаалийн байгууллагыг төлөөлөн ГЕГ-ын дэд дарга Г. Энхтайваны хамт онлайнгаар оролцсон. - ДГБ-ын “Бүрдүүлэлтийн дараах шалгалтын чиглэлээрх үндэсний семинар”-ыг МУ-д зохион байгуулан гаалийн албан хаагч нарыг хамруулсан. 	01.01-11.30

					<ul style="list-style-type: none"> - ДГБ-ын Гаалийн байгууллага дахь “Жендерын тэгш ба ялгаатай байдлын” чиглэлээрх гишүүн орнуудын туршлагыг харуулсан гарын авлагын 3-р хувилбарт Монголын гаалийн байгууллагын талаар жишээ, кэйс, мэдээллийг дурдан нийтлэлийг бэлтгэж ДГБ-ын Чадавхыг бэхжүүлэх хорооны Жендерын асуудал хариуцсан мэргэжилтэн Жоханна руу илгээсэн. - Монголын гаалийн байгууллага болон БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага болох КОЙКА-н “Эрсдэлийн удирдлагын систем болон барааг сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-д (2025-2027 он) шалгарч, төслийн судалгаа хийх баг МУ-ын ГЕГ-т 2024 оны 11 сарын 25-29-ний өдрүүдэд ажилласан бөгөөд уг уулзалтыг зохион байгууллахад хамтран ажилласан. - ГЕГ-ын БДШГ -ын “МУ-ын гаалийн байгууллагын БДШ шинэчлэлийн” талаарх нийтлэлийг бэлтгэхэд оролцож ДГБ-ын хэвлэл мэдээллийн алба руу 2024 оны 7-р сарын 22-ны өдөр илгээсэн байна. 	
3	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримт орчуулж, гадаад хурал, арга хэмжээнд албан ёсны орчуулга хийх ажлыг зохион байгуулж, орчуулгын талаар оновчтой тайлагнах.	<p>Монгол Улсад 21 арга хэмжээ зохион байгуулсан. Тус арга хэмжээнүүдэд албан ёсны орчуулга хийхийн сацуу Гадаад хамтын ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримтыг орчуулан ажилласан. Үүнээс 19 уулзалт, үндэсний хэмжээний 2 сургалт зохион байгуулж 178 албан хаагч хамруулах ажлуудад оролцож ажилласан байна (Орчуулсан материал: 53 презентаци, 292 гаруй хуудас материал: хурал дараглагчийн үг, ярианы сэдэв, уулзалтын тэмдэглэл, протокол г.м).</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-аас 2024 оны 03 дугаар сарын 25-29-ны өдрүүдэд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулагдсан “Гарал үүслийн үндэсний семинар”-ийн хөтөлбөр, зохион байгуулах ажилд ажиллаж, семинарын үеэр оролцогч нарт тараах сургалтын гарын авлага, илтгэлийг Анг-Мон хэл рүү орчуулж бэлэн болгосон байна. - Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гадаад бичиг баримтуудыг орчуулж, ОУВС-ийн “Азийн орнуудын гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд ГЕГ дээр ирж ажилласан ОУВС-ын төсвийн орлогын газрын зөвлөх багтай 2024 оны 04-р сарын 01-ний өдөр ГЕГ-ын дарга болон холбогдох нэгжийн удирдлага нар хүлээн авч уулзсан бөгөөд уг арга хэмжээний бэлтгэл ажил, хуваарьт уулзалтуудыг товлох, албан ёсны орчуулга хийсэн. - Монгол Улсын Гаалийн ерөнхий газар болон Тайландын Хаант Улсын хооронд Гаалийн асуудлаар хамтран ажиллах харилцан 	01.01-11.30

					<p>туслалцах тухай санамж бичгийн албан бус орчуулгыг хийж удирдлагад танилцуулан ГХЯ ба СЯ-аар хянуулахаар бэлэн болгосон бөгөөд уг санамж бичигт ГЕГ-ын Дарга Р. Отгонжаргал Австрали улсын Сидней хотноо 2024 оны 04 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан ДГБ-ын АНДБН-ийн Гаалийн байгууллагын дарга нарын ээлжит уулзалтаар Тайландын Хаант Улсын гаалийн байгууллагатай "Гаалийн асуудлаар хамтран ажиллах, харилцан туслах тухай санамж бичгийг байгуулсан.</p> <ul style="list-style-type: none"> - Дэлхийн гаалийн байгууллага болон Швейцарын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын хамтарсан "Глобал худалдааг хөнгөвчлөх хөтөлбөр"-ийн 2-р үе шатыг эхлүүлэх Төслийн замын зураг боловсруулах, төлөвлөгөө гаргах арга хэмжээ 2024.07.01-05-ны өдрүүд Гаалийн ерөнхий газарт зохион байгуулагдсан бөгөөд уг арга хэмжээний нээлтийн үйл ажиллагаанд ГЕГ-ын дэд дарга Г. Энхтайван үг хэлсэн бөгөөд уг нээлтийн арга хэмжээний орчуулгыг хийсэн. - Дэлхийн Гаалийн Байгууллага (ДГБ)-аас Бүрдүүлэлтийн дараах шалгалт (БДШ) чиглэлээр Бүрдүүлэлтийн дараах шалгалтын үндэсний семинарыг 2024 оны 10 сарын 07-11-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо Гаалийн ерөнхий газарт Япон Улсын Гаалийн хамтын ажиллагааны сангийн (CCF) санхүүжилттэйгээр зохион байгуулсан бөгөөд уг семинарыг зохион байгуулахаар хүрэлцэн ирсэн төлөөлөгч нарыг ГЕГ-ын дэд дарга Г. Энхтайван хүлээн авч уулзсан бөгөөд уг нээлтийн хуралд орчуулга хийж ажилласан. - Гаалийн байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд хүргэх зорилгоор ОНХА-аас бэлтгэсэн Видео контентын Мон-Анг орчуулгыг орчуулж, Монголын гааль фэйсбүүк пэйж хуудсанд Англи хамдмал орчуулгатайгаар нийлтэлсэн байна. - Түүнчлэн ДГБ болон бусад хамтран ажиллагч байгууллагаас цахимаар ирүүлсэн Захидал, сургалт семинарт хамрагдах урилга, хүсэлт, албан бичгийг тухай бүрт цаг алдалгүй орчуулж албан хаагчдыг чадавхижуулах чиглэлд Гадаад болон дотоодын богино хугацааны сургалт семинарт амжилттай хамруулан ажилласан. 	
4	ДГБ бусад олон улсын байгуулагтай хамран ажиллаж,	Хэрэгжилт, гүйцэтгэл эр	-	ДГБ болон бусад олон улсын байгууллагатай (ДГБ, НҮБ, ОУВС, Их түмэн	ДГБ бусад олон улсын байгууллагатай хамран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд "Олон улсын гаалийн өдөр 2024" өдөрлөгийг цахим хэлбэрээр амжилттай тэмдэглэн өнгөрүүлсэн.	01.01-11.30

	гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулсан байдал			санаачилга, КАРЕК гэх мэт) хамтран ажиллаж, гаалийн байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна.	Энэ нь ДГБ-ын бодлого, чиглэл, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, зургийн уралдаан зэрэг 10 чиглэлээр цахим гарын авлага, видео, постер, брошураар гаалийн байгууллагын хамт олонд, цахим, цаас, олон нийтийн хуудсаар түгээж, ДГБ-ын зөвлөмж, тэргүүн туршлагыг албан хаагчдад үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд дэмжлэг болсон. Түүнчлэн ДГБ, ОУВС, НУБ, КАРЕК, АНУ, БНСУ, БНХАУ, ОХУ, Япон болон бусад орны гаалийн байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтран албан хаагчдын мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлэх, олон улсын тэргүүн туршлагыг судлуулах зорилгоор цахим болон биет хэлбэрээр нийт 75 арга хэмжээг (гадаад улсад 73: 174 албан хаагч; үндэсний 2: 73 албан хаагч) зохион байгуулж 247 албан хаагч хамруулсан. Олон улсын тэргүүн туршлага, арга хэрэгслийг судалж санал, зөвлөмж боловсруулах, үйл ажилаагаандаа нэвтрүүлэх зорилгоор 73 гадаад арга хэмжээнд оролцсон 174 албан хаагчдийн тайлан болон ДГБ, бусад олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрийн мэдээллийг ЗДС СЕРП програмаар түгээсэн (Хандалт: 3022).	
5	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Нэгжийн чиг үүргийн хүрээнд "Гаалийн байгууллагын үйл ажиллагаанд хяналтшинжилгээ хийх, үр дүнг үнэлэх аргачлал"-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тайлагнасан байна.	"Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө", "Алсын хараа 2050" хөтөлбөрийн хүрээнд тус нэгжийн үйл ажиллагаанд хамаарах тайлан мэдээ байхгүй болно.	01.01-11.30
7	Нэгжийн эрсдэлийн Үйл ажиллагаа удирдлагыг хэрэгжүүлсэн байдал		-	Нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож ажилласан. Өмнөх онд тайлагнаж байгаагүй.	Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулахад тус нэгж анхаарал хандуулан ажилласан. Одоогийн байлаар орон тоо дутуу ажиллаж байгаа нь албан хаагч нарт ачаалал ирснээр ажлаас халшрах эмгэг ихэссэн. Түүнчлэн гадаад хамтын ажиллагааны хэлтэс нь ихэнх тохиолдолд европын цагаар буюу гадаад орны гаалийн байгууллагатай идэвхитэй холбоо барихын тулд ажлын бус цагаар ажилдаг. Түүнчлэн гадаадын зочид төлөөлөгчдийг шөнөөр тосох хүргэж	

					өгөх зэрэг нойргүй ажилласны дараа цаг бүртгүүлэх төхөөрөмжид бүртгүүлэх нь хүндрэл учруулдаг. Иймд албан хаагч нарын Ажил-Амьдралын тэнцвэрийг хангахын тулд ажил үүргийн хуваарийг уян хатан байдлаар өөрчлөх, илүү цагаар ажилласан цагийг ажлын өдөр нөхөн өгөх, эсхүл илүү цагийн мөнгийг нь олгуулах судалгаа хийж ажиллаж байна.
8	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх		-	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг тухай бүр ханган ажиллаж, тайлагнана.	<p>Удирдлагаас өгсөн 4 үүрэг даалгаврыг цаг тухайд нь 100% биелүүлэн ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - ГЕГ-ын даргын гадаад уулзалт, ажлын тайланг Сангийн Яам болон Гадаад Харилцааны Яаманд албан бичгээр хүргүүлсэн. - Дэлхийн Гаалийн Байгууллагын Ази, Номхон далайн бүс нутгийн Гаалийн дарга нарын 25 дугаар дээд хэмжээний уулзалт Австрали Улсын Сидней хотод 2024 оны 04 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, Номхон Далайн бүсийн 35 орны Гаалийн байгууллага (биетээр 32, цахим 3), Дэлхийн Гаалийн Байгууллагын Ерөнхий Нарийн Бичгийн Даргын Газар, Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Чадавхыг бэхжүүлэх төв, Бүс нутгийн Зөрчлийн мэдээлэл солилцсон ажлын хүрээнд холбогдох мэдээллийг Гаалийн байгууллагын Захиргаа, Дотоод Ажлын систем программд дэлгэрэнгүй тайлан, холбогдох мэдээллийг Гадаад арга хэмжээ талбарт байршуулж, гаалийн албан хаагчдын мэргэшлийн мэдлэгийг дээшлүүлж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. - Гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны А/69 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандарт", 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдгийг хэрэглэх журам"-ыг нийт албан хаагчиддаа танилцуулсан. ЗУГ-т 2024 оны 03-р сарын 13-ны өдөр 46 тоот дотоод зурвасаар хариу хүргүүлсэн. - Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/251 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Гаалийн улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам"-ын хэрэгжилтийг хангаж, журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа
	1	2	3	4	5	6
1	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Гадаад хэл дээрх мэдээллийн эх сурвалжийг харьцуулан судлана.	Гаалийн хөгжлийн чиг хандлагаас суралцаж, дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхахын тулд ДГБ-ын вебсайт https://www.wcoomd.org/ болон фэйсбүүк пэйж хуудсаар тогтмол зочилж сүүлийн үеийн мэдээ, мэдээлэлтэй байнга танилцаж өдөр тутмын үйл ажиллагаа, орчуулгадаа ашиглаж байна.	01.01-11.30
2	Богино хугацааны мэргэшлийн мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг болж ажилласан байна.	<ol style="list-style-type: none"> 1. ДГБ-ын Гарал үүслийн үндэсний семинар 2024 оны 03 дугаар сарын 25-29 өдөр УБ хот 2. ОУВС-ийн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үндэсний семинар 2024 оны 04 дүгээр сарын 08- 10 өдөр УБ хот 3. Их Түмэн Санаачилгын Гаалийн дэд хорооны 6-р хуралдаан, Худалдаа, хөрөнгө оруулалтын хорооны 6-р хуралдаан 2024 оны 05 дугаар сарын 29-30 өдөр УБ хот 4. WCO-Click Gender equality and inclusion in Customs (онлайн) 5. WCO-Click Gender equality in Customs сургалт (онлайн) 6. ДГБ-ын Онлайн гаалийн академийн сургалт (VCOA) (онлайн) 7. ДГБ-аас 2024 оны 10-р сарын 01-ний өдөр зохион байгуулсан "Гаалийн байгууллага дахь Жендерийн тэгш ба ялгаатай байдал"-ын хурал (онлайн) 8. БНСУ-ын Инчеон гаалийн бүстэй танилцах, туршлага судлах сургалт 2024.10.21-25 (БНСУ, Инчеон хот) зэрэг сургалтуудад онлайн болон биет хэлбэрээр тайлант хугацаанд хамрагдсан байна. 	01.01-11.30

ТАЙЛАН ГАРГАСАН:

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ

.....*Мидва*.....

/Э.ЭНХТУЯА /

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭНХБАЯР ОВОГТОЙ ЭНХТУЯАГИЙН
2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн Ерөнхий Газар

Нэгжийн нэр: Гадаад хамтын ажиллагааны хэлтэс

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Олон улсын гаалийн чиглэлээр хэрэглэж буй баримт бичгийг судлаж, боловсруулсан байдал	55	10	65	
2	Хамтын ажиллагааны арга хэмжээг зохион байгуулсан байдал, гэрээ хэлцэл, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт	58	10	68	
3	Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг олон улсын стандартын дагуу бүрэн хэрэгжүүлэх, хөтөлбөрийн хүрээнд байгуулсан; Харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх	56	10	66	
4	Олон улсын түвшинд хэрэглэгдэж байгаа дэвшилтэт арга барил, технологи, техник ажиллагааг нэвтрүүлсэн байдал	58	8	66	
5	Гадаад худалдааг хөнгөвчлөх	60	10	70	

Зорилт 2. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх” зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт				
1.	Албан хаагчдыг уулзалт, сургалтад хамруулсан байдал, үр дүнг тооцох ажлыг зохион байгуулна.	55	10	65
2.	Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг гадаад орнуудад сурталчилсан байдал	56	9	65
3.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	58	10	68
4.	Хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	55	10	65
5.	Үүрэг даалгаврын биелэлт	58	8	66
6.	Ажлын цаг ашиглалт	60	10	70
7.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	58	10	68
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт				
1.	Цаг үеийн асуудлаар удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	56	10	66
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2	58	10	68
Дундаж оноо: 66.8				

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	Онлайн гаалийн академийн сургалтад хамрагдах	95	14	
2.	Гаалийн холбогдолтой үндэсний сургалт семинарт хамрагдах	95	14	
3.	Мэргэжлийн Англи хэлний мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх	96	14	
Дундаж оноо:			14	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	6	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1. Англи хэл	7	
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	6	
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	6	
Дундаж оноо:		6,6	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо: 7,3		


5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (<i>Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно</i>)	66,8
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Нэгжийн даргын үнэлгээ</i>)	6,6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (<i>Хамт олны үнэлгээ</i>)	7,3
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (<i>Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих</i>)	
Нийт оноо =94,7		

Үнэлгээ өгсөн:

ГХАХ-ийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга


.....
(гарын үсэг)

/Ө. Цолмон/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

ГХАХ-ийн ГУБ
(албан тушаал)


.....
(гарын үсэг)


/Э.Энхтуяа/
(албан хаагчийн нэр)

..... (огноо)


Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)


.....
(гарын үсэг)

/Г. Энхтайван/


..... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

ХНХ-ийн ГУАБ
(албан тушаал)



.....
(гарын үсэг)

/Ө. Тэгшээ /

..... (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Гаалийн ерөнхий газрын дарга
(албан тушаал)


Төсвийн шууд захирагч
.....
(гарын үсэг)

/P. Отгонжаргал/

..... (огноо)